



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/540

Булган сум

Хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Олимп, Дэлхий, Тив, Олон улс, Үндэсний спорт, Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчдад урамшуулал олгох журам батлах тухай” ХХ/08 дугаар тогтоол, 2024 оны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/69 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний их баяр наадам Тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улсын 819 жил, Ардын хувьсгалын 104 жилийн ойн Улсын баяр наадамд 5 даван шөвгөрч “Өсөх идэр” чимэг нэмсэн Булган аймгийн Орхон сумын харьяат Улсын начин Б.Түмэндэмбэрэлийг 5,000,000 (таван сая), модон барилдааны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль хүртсэн Э.Орхонтамир, М.Мягмардорж, хүрэл медаль хүртсэн Ц.Базаррагчаа, Л.Чимэгсүрэн нарт тус бүр 500,000 (таван зуун мянга), Монгол Улсын “Гавьяат тээвэрчин” цол хүртсэн Тэшиг сумын харьяат аймгийн Хурц, бадрангуй арслан Н.Батчулуунд 1,000,000 (нэг сая) төгрөгийн хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Хүндэтгэл үзүүлэхэд шаардлагатай 8,000,000 (найман сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР